

“ Э-ТРАНС ЛОЖИСТИКС “ ХК-НЫ 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

- **Үнэт цаас гаргагчийн нэр, оршин суугаа хаяг;**
Хаяг: Дорноговь аймаг, Замын Үүд сум, 1-р баг 10-р хэсэг, Э-Транс Ложистикс ХК-ны байр
Утас: 02524543813, 99117636, 95956390
Электрон хаяг: www.etr.mn
- **Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл;**
Компанийн нэр: “ Э-транс Ложистикс “ ХК
Улсын бүртгэлд бүртгэсэн огноо: 2011.12.06
Улсын бүртгэлийн дугаар: 0610001001
Регистрийн дугаар: 3309665
Үйл ажиллагааны чиглэл: Ачаа шилжүүлэн ачих терминал
Хувьцаа эзэмшигчдийн тоо:
- **Товч танилцуулга;**



Э-Транс ложистикс Хувьцаат компанийн хяналтын багцыг эзэмшигч Э-Транс Хязгаарлагдмал хариуцлагатай компани нь 2007 оноос Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 1-р багийн нутагт төмөр зам дагасан байрлалд салбар зам барин ачаа шилжүүлэн ачих терминал байгуулах төсөл хэрэгжүүлснээр манай компанийн үйл ажиллагааны эхлэл тавигдсан.

2007-2008 онд шилжүүлэн ачих терминалын бүтээн байгуулалтыг хийж ашиглалтанд оруулсан бөгөөд 2009 оны 4 дүгээр сард анхны тээврийн хэрэгслээс вагонд шилжүүлэн ачих ажлыг хийж гүйцэтгэсэн.

2010 онд шилжүүлэн ачих терминалын үйл ажиллагааг тусгаарлан Э-Транс ложистикс хязгаарлагдмал хариуцлагатай компанид шилжүүлсэн.

2012 оны 04 сард Монголын Хөрөнгийн бирж дээр бүртгүүлэн хувьцаат компани болсон ба 924 сая төгрөгийн хөрөнгө оруулалт татан техник тоног төхөөрөмж, барилга байгууламж, дэд бүтцээ сайжруулах, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулсан.

2011 онд Э-Транс ложистикс ХХК-нд үйл ажиллагаа нь шилжин ирсэнээс хойш нийт 25,181 вагон буюу 1,611,584.84 тонн ачааг шилжүүлэн ачиж харилцагч байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн захиалгын дагуу түргэн шуурхай, найдвартай хүргүүлж ажилласан байна.

1.1 Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл;

Компанийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн баталсан бөгөөд нийт 3 бүлэг, 39 ажил хийхээр төлөвлөгдсөн. Үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргахдаа өмнө жилүүдэд хийгдэхээр төлөвлөгдсөн боловч тодорхой шалтгаануудын улмаас саатсан зарим ажлуудыг энэ онд хийж гүйцэтгэх боломжтой гэж үзэн төлөвлөсөн боловч санхүүгийн нөхцөл байдалтай уялдан худалдан авалттай холбоотой зарим ажлууд хийгдэх ёстой хугацаанаасаа хоцорч тасарсан.

Төмөр замтай холбоотой хийж гүйцэтгэхээр заагдсан ажлууд улс орны эдийн засгаас хамааран төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байгаа бөгөөд энэхүү байдлыг 1.3, 1.4 дэх хэсгүүдэд үзүүлсэн график, тоон мэдээнээс харж болно.

Компанийн үндсэн үйл ажиллагаа эдийн засгийн байдлаас шалтгаалан доголдож байгаа тул өөрсдийн нөхцөл байдалдаа түшиглэн зарим салбар үйл ажиллагаагаа өргөжүүлэх шаардлага гарч байгаа бөгөөд энэ ажлыг компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд төлөвлөн төлөвлөгөөний дагуу холбогдох судалгаануудыг хийж зарим ажлыг туршилтын журмаар хийж гүйцэтгэж байна.

Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд заагдсан үндсэн үйл ажиллагаатай болон худалдан авалттай холбоотой хийгдэхээр заагдсан ажил, үйлчилгээнүүд хийгдэхээр заагдсан хугацаандаа бүрэн хийгдэж хэрэгжилтийн хувь 90 гаран хувьтай байна.

Цаашид компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд өмнөх онуудад хийгдэхээр заагдсан боловч тодорхой шалтгааны улмаас тасарсан ажил үйлчилгээнүүдийг хийж гүйцэтгэхээр зааж өгөх болон худалдан авалттай холбоотой ажил үйлчилгээг эдийн засгийн боломж бололцоо, үйл ажиллагааны чиглэл зэрэгт нийцүүлэн шийдвэрлэхээр болсон.

1.2. Компанийн эрхэлж буй үйл ажиллагааны салбарт эзлэх байр суурь;

Тус компанийн ажил үйлчилгээний гол хэлбэр нь ачаа шилжүүлэн ачих үйл ажиллагаа бөгөөд үйл ажиллагаа явуулж байгаа нутаг дэвсгэр дэх шилжүүлэн ачих бусад терминалуудаас дараах хүчин зүйлсээр давуу талтай байдаг.

1. Газар нутгийн байрлал: Компани нь БНХАУ-тай хиллэдэг улсын хилээс 5 км, худалдаа, аялал жуулчлалын чөлөөт бүс Эрээн хотоос 10 км, хилийн шалган нэвтрүүлэх 3-р цэгээс 100 метрийн зайд байрладаг.


2. Нэг дороос үйлчилгээ авах боломжтой: Тус компанийн гаалийн хяналтын бүсээр зарлагдан үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш гаалийн нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлэн үйлчлүүлэгч нарын цаг, хөдөлмөрийг хэмнэж ирсэн. Мөн ачаа барааг шилжүүлэн ачих ачигч нарыг үйлчлүүлэгч нарт зуучлан ачаа барааг нь түргэн шуурхай найдвартай шилжүүлэн ачих үйлчилгээг үзүүлдэг.

3. Техник тоног төхөөрөмжийн цогц үйлчилгээ: Үйлчлүүлэгч нарын хүсэл шаардлагад нийцүүлэн ачаа барааг шилжүүлэн ачих ажиллагаанд техник тоног төхөөрөмжийг ашигласнаар шилжүүлэн ачих үйл ажиллагаа түргэн шуурхай, элдэв гологдолгүй, бүрэн бүтэн захиалагч нарт хүргэгдэх нөхцөл бүрддэг.

4. Харуул хамгаалалтын найдвартай байдал: Тус компани 24 цагийн харуул хамгаалалтыг харуул хамгаалалтын алба хаагч нараар гүйцэтгүүлдэг бөгөөд харуул хамгаалалтын пост, төв оффисоос хяналтын IP камерын системээр гаалийн хяналтын бүс, ачилтын талбай, орж гарах үүд зэрэг бүх газрыг хянадаг.

5. Гаалийн баталгаат агуулах, хяналтын бүсийн цогц үйлчилгээ: Үйлчлүүлэгч нар нь өөрийн ачаа бараагаа холбогдох хууль тогтоомжийн дагуу гаалийн баталгаат агуулах, гаалийн хяналтын бүсэд төлбөртэйгээр хадгалуулж хүссэн үедээ хүлээн авах боломжтой.

Доорх зургаар тус суманд үйл ажиллагаа эрхэлж байгаа бусад терминалын байдлыг харуулав.



Зураг 1. Улаанбаатар төмөр замын харьяа шилжүүлэн ачих терминал МЧ 1, хилийн хяналтын цэгээс 6 км орчим зайтай, нарийн болон өргөн царигийн вагон

хооронд хүнд даацын ачаа шилжүүлэн ачих болох хялбар муудах ачаа, чингэлгийг шилжүүлэн ачдаг. Гол онцлог нь нэг цэгийн үйлчилгээтэй, хүнд даацын ачааг гүүрэн кранаар шилжүүлэн ачдаг.



Зураг 2. Улаанбаатар төмөр замын харьяа шилжүүлэн ачих терминал МЧ 2, хилийн хяналтын цэгээс 4 км орчим зайтай, нарийн царигаас өргөн царигийн вагонд болон автомашинаас вагонд чингэлэг шилжүүлэн ачдаг. 2016 оны 07 дугаар сарын 1-нээс чингэлэг буулгахыг больж Улаанбаатар хотод буулгадаг болсон.

Улаанбаатар төмөр замын шилжүүлэн ачих терминалууд МЧ 1, МЧ 2 нь хүчин чадал сайтай, хүн хүчний бололцоо их боловч хамгийн хүндрэлтэй зүйл нь тухайн терминалуудад хүрч очиход хол, зам нь Замын-Үүд сум дундуур явдаг нь бэрхшээлтэй байдаг.



Зураг 3. Улаанбаатар төмөр замын шилжүүлэн ачих терминал МЧ 3, хилийн хяналтын цэгээс 11 км орчим зайтай, автомашинаас вагонд цемент шилжүүлэн ачдаг мөн барилгын материал болон өргөн хэрэглээний бараа шилжүүлэн ачих ажлыг хийж гүйцэтгэдэг.

1.3. Компанийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбоотой үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл;


2016 онд улс орны эдийн засгийн уналттай холбоотойгоор худалдан авах чадвар буурч үйлчлүүлэгч байгууллага, аж ахуйн нэгж, иргэд багассан, Улаанбаатар төмөр замаас өөрийн бизнесийг дэмжсэн бодлого явуулж тээврийн зардлаа өсгөсөн, үүнийг дагаад иргэд, аж ахуйн нэгжээс төмөр замаар ачаа бараагаа тээвэрлүүлэх сонирхол багасч авто замаар тээвэрлэх сонирхол өссөн зэрэг манай үндсэн үйл ажиллагааг доголдуулсан нөхцөл байдлууд үүссэн.

2017 онд хийж гүйцэтгэсэн ачаа шилжүүлэн ачих үйл ажиллагаа өмнөх жилүүдэд зохион байгуулсан шилжүүлэн ачих үйл ажиллагаанаас эрс багассан үзүүлэлттэй байгааг хүснэгтээс харж байна. Энэ нь өмнөх жилүүдийн адил улс орны эдийн засгийн хүндрэлтэй байдал, иргэд аж ахуйн нэгжийн худалдан авах чадварын бууралт зэрэг гадаад хүчин зүйлсээс үүдэлтэй юм. Барилгын салбар дахь гол хэрэглэгдэхүүн цементийн хэрэгцээг дотоодын үйлдвэрүүд хангах болсноос хойш цементийн импорт зогссон нь өмнөх жилүүдэд шилжүүлэн ачсан ачааны тоо хэмжээг эрс багасгасан. Гэхдээ 2016 оны мөн үеийнхийг бодвол барилгын төрөл бүрийн ачаа болон модон материалын шилжүүлэн ачилт нэмэгдэж цаашид ч нэмэгдэх хандлагатай байна. Энэ нь сүүлийн жилүүдэд улс оронд үүсээд байсан эдийн засгийн байдалд эерэг үзүүлэлт гарч зогсонги байсан салбарууд сэргэх байдалтай байгаа нь нөлөөлж байна.

Хүснэгт 1. Ачилтыг ачааны төрлөөр нь ялгаж харуулсан нь:

Сар	Цемент	Барилгын төрөл бүрийн материал	Кран	Модон материал	Бусад	Нийт
1		18	3	5	2	28
2		17		1	2	20
3		23	2	8	4	37
4		109	1	12	11	133
5		91	19	12	14	136
6	52	99	8	11	12	182
7	27	91	5	7	12	142
8		90	3	13	5	111
9		85	1	5	8	99
10		67	3	9	4	83
11		37	7	7	14	65
12		29	17	10	25	81
Нийт	79	756	69	100	113	1117

График 1. 2016 оны мөн үеийг 2017 оны мөн үетэй харьцуулсан байдал



Дээрх графикаас харвал компанийн үндсэн үйл ажиллагаа нь улс орны эдийн засгийн байдлаас шалтгаалан өмнөх жилийн мөн үеийнхээс олон дахин буурсан байгаа ба оны сүүлийн саруудад багахан хэмжээгээр өссөн үзүүлэлттэй байгаа нь харагдаж байна.

1.4. Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаанд гарсан томоохон үйл явдлын талаарх мэдээлэл;

Компанийн үндсэн үйл ажиллагааны болох ачилт буултын тоо багассан зэрэг сөрөг үйл явдал оны эхнээс гарсан нь компанийн үйл ажиллагааг ихээхэн хэмжээгээр доголдуулсан тул алдагдалыг бууруулах, түүнийг нөхөж болох үйлчилгээг нэвтрүүлэх шаардлага гарсан ба удирдлагаас холбогдох газруудтай хамтран зарим ажлуудыг судлан хийж гүйцэтгэлээ.

Үүний нэг нь Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газартай ярилцан тохиролцсоны үндсэн дээр тээврийн хэрэгсэлээр экспортоор орж байгаа ачаа барааг өөрийн баталтгаат автопүүн дээр пүүлэн гаргах ажлыг оны эхнээс хийж гүйцэтгэлээ. Ингэснээс авто тээврийн хэрэгсэлээр хилээр гарч байгаа бүх экспортын ачааг тус компанийн пүүгээр пүүлэн түүнээс үйлчилгээний хураамж авч байх нөхцөл бүрдсэн. 2017 оны сүүлийн хагасаас эхлэн БНХАУ руу экспортолж байгаа махны хэмжээ мэдэгдэхүйц өссөн бөгөөд махны экспортын бүх ачааг тус компанийн гаалийн баталгаат пүүн дээр пүүлж гаргасан ба цаашид ч энэ ажил үргэлжилж байна.

Хүснэгт 2. Пүүлсэн экспортын ачааны тоо

Он	Экспортын ачааны тоо	Пүүлсэн үйлчилгээний хураамж
1 сар	15	136,364

2 сар	10	86,364
3 сар	-	-
4 сар	20	509,091
5 сар	87	933,636
6 сар	85	1613,636
7 сар	120	2181,818
8 сар	150	2727,272
9 сар	100	1818,182
10 сар	190	3454,545
11 сар	98	1781,818
12 сар	105	2157,365
Нийт	980	17400,091

Мөн үүнээс гадна суудлын тэрэгний татвар нэмэгдэхтэй холбогдуулан машин импортлогч нараас суудлын машин бөөнөөр оруулж ирэх болсонтой холбогдуулан Гаалийн байгууллагатай хамтран тус компанийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэлийг ашиглан чингэлгээр оруулж ирсэн суудлын болон ачааны машинуудыг буулгах ажлыг зохион байгуулсан. Энэхүү ажлыг 2017 оны 05 дугаар сарын 01 болон 07 дугаар сарын 01-нээс өмнөх өдрүүдэд өндөр ачаалалтайгаар гүйцэтгэсэн ба Гаалийн байгууллагаас тус компанийн өндөрлөсөн тавцан, өөрөө буулгагч зэрэг тоног төхөөрөмжүүдийг ашиглан цаашид чингэлгээр оруулж ирсэн тээврийн хэрэгсэлийг буулгах ажлыг үргэлжлүүлэхээр болсон.

Хүснэгт 3. Чингэлэг буулгах үйлчилгээ


Он	Импортоор орж ирсэн чингэлэгийн тоо	Тээврийн хэрэгсэл буулгах үйлчилгээний хураамж
1 сар	-	-
2 сар	-	-
3 сар	-	-
4 сар	10	909,091
5 сар	80	7272,727
6 сар	39	3581,818
7 сар	4	727,272
8 сар	2	363,363
9 сар	2	363,363
10 сар	3	545,454
11 сар	4	727,272
12 сар	-	-
Нийт	129	14490,360

Эдийн засгийн уналт, худалдан авах чадвар багассан, төмөр замын үнийн бодлого зэргээс шалтгаалан тус компанийн үндсэн үйл ажиллагаа хагас жилүүдийн байдлаар хэрхэн буурсан байдлыг харууллаа. Үүнээс гадна ачилтын график, ачигдсан вагоны тоо хэмжээ ихээхэн хэмжээгээр буурсан харагдаж байгаа нь 2012-2016 онуудад голчилон ачигдаж байсан зарим төрлийн ачаа импортоор орж ирэхгүй болсонтой холбоотой юм.

Хүснэгт 4. 2013-2017 оны хагас жилээр ачигдсан вагоны тоо / сараар /

Сар	2013 он	1014 он	2015 он	2016 он	2017 он
1.	228	170	100	113	28
2.	95	70	76	82	20
3.	262	334	439	195	37
4.	403	301	955	549	133
5.	360	291	946	699	136
6.	463	301	921	518	182
7.	511	450	989	376	142
8.	329	652	1062	312	111
9.	358	451	946	106	99
10.	436	231	647	59	83
11.	319	132	154	41	65
12.	117	156	134	19	81
Дүн	3,881	3,539	7,369	3,069	1,117

График 2. 2012-2017 оны ачилт, буултын харьцуулсан үзүүлэлт / жилээр /



Буулт нь 2017 оны мөн үеийн хэмжээнд байгаа ч гэсэн 2012 оноос тогтмол буурч байгаа бөгөөд үүний шалтгаан нь арьс шир, дайвар бүтээгдэхүүн, хуванцар зэрэг түүхий эдийн экспорт автозамаар тээвэрлэгдэх болсонтой холбоотой юм.

Хүснэгт 5. Орлогыг нэр төрлөөр нь харуулсан нь /мян төгрөг/

д/д	Орлогын нэр	2016 он	2017 он	Зөрүү	Өсөлт /бууралт/
1	Ачилт	412,416.27	160,252,04	-252,164.23	-61.14%
2	Буулт	12,539.64	10,320,00	-2,219.64	-17.7%
3	Хадгалалт агуулах	82,708.11	20,397,88	-62,310.23	-75.3%

4	Гарах хуудас	43,180.91	118,828,18	75,647.27	1.75 дахин
5	Түрээс	32,318.27	37,500,00	5,181.73	16%
6	Цайны газар	61,517.36	87,785,81	26,268.45	42.7%
7	Бусад	2,581.64	35,268,77	32,687.13	12 дахин
	Нийт	648,539.00	470,374,36		

Хүснэгт 6. Гаалийн хяналтын бүсэд гаалийн бүрдүүлэлт хийхээр нэвтэрсэн машины тоо хураамж

Сар	Гаалийн хяналтын бүсэд нэвтэрсэн тээврийн хэрэгсэл		Хяналтын бүс болон агуулахад ачаа бараа хадгалсны хураамж
	Тоо	Хураамж	
1 сар	296	3,464,545.45	-
2 сар	178	1,366,363.64	-
3 сар	395	5,395,454.55	-
4 сар	631	8,517,272.73	1 935 000
5 сар	824	10,676,363.64	-
6 сар	992	14,080,909.09	-
7 сар	1017	9,627,272.73	204 545
8 сар	943	14,358,181.82	8 717 236
9 сар	1170	21,550,909.09	40 909
10 сар	691	11,539,090.91	9 500 195
11 сар	912	7,989,090.91	
12 сар	479	10,262,727.27	
Нийт дүн	8528	118,828,181.82	20 397 885

Монгол улсын Засгийн газраас уул уурхайн салбарыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх шийдвэр гаргаснаас хойш уул уурхайн хүнд машин механизмын импорт нэмэгдэж үүнийг дагаад тус гаалийн хяналтын бүсэд бүрдүүлэлт хийгдэхээр оруулж ирсэн тээврийн хэрэгсэл нэмэгдэж үйлчилгээний хураамж мөн дагаж нэмэгдсэн. Үүнээс гадна бусад адил төстэй үйл ажиллагаа явуулж байгаа гаалийн хяналтын бүсүүдийн жишгийг дагаж үйлчилгээний хураамжаа тодорхой хэмжээгээр нэмэгдүүлсэн нь хяналтын бүсийн үйлчилгээнээс оруулж байгаа орлогыг нэмэгдүүлсэн нь хүснэгтээс харагдаж байна.

Баталгаат агуулахад хадгалуулсан ачаа барааны тоо өмнөх оныхоос их байгаа ч орлого тодорхой хэмжээгээр буурсан үзүүлэлттэй гарсан нь олон төрлийн ачаа барааг хадгалуулахдаа удаан хугацаагаар хадгалуулахгүй байсантай холбоотой юм. 2017 онд гаалийн баталгаат агуулахыг болон баталгаат агуулахын зорилгоор ашиглаагүй байгаа агуулахуудаас зарим агуулахыг хүнсний болон бусад төрлийн ачаа, бараа хадгалах зориулалтаар тохижуулах, хөргөлттэй агуулах болгох талаар судалгаа хийж, хамтран ажиллах аж ахуйн нэгжүүдтэй холбоотой ажилласан бөгөөд 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд зарим ажлуудыг хийж гүйцэтгэх боломжийг судлан ТУЗ-д танилцуулж шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

2012 онд барьж ашиглалтанд оруулсан нэг цэгийн үйлчилгээний байранд 20-25 хүний багтаамжтай ажилчдын цайны газрыг ажиллуулж байгаа бөгөөд одоо энэ цайны газарт зөвхөн ажилчид биш нэг цэгийн үйлчилгээ үзүүлж байгаа гааль, мэргэжлийн хяналтын алба хаагчид, гаалийн үйлчилгээ авч байгаа үйлчлүүлэгч нар үйлчлүүлэхийн зэрэгцээ манай байгууллагатай ойролцоо ажил үүргээ гүйцэтгэж байгаа авто тээвэр, хилийн цэрэг, цагдаагийн алба хаагчид үйлчлүүлж байна.

Тус цайны газарт өдөрт дунджаар 50-70 хүн үйлчлүүлдэг бөгөөд компанийн үндсэн үйл ажиллагаа буурсан үед цайны газрын орлого зарим төрлийн зардлыг хасах боломжийг олгож өгдөг. Цайны газрын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор мэргэжлийн тогоочийн сургалтанд 3 ажилчинг 1 сарын хугацаатай суралцуулсан. Үндсэн үйл ажиллагааны орлого багассан өнөө үед цайны газрыг тогтмол ажиллуулж, чанартай хоол цайгаар иргэдэд үйлчлэх нь эдийн засгийн хувьд нэмэртэй үйл ажиллагаа болж байна.

1.5 Компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлын тайлан


Тус компани нь үйл ажиллагаа явуулж байгаа орон нутагтаа буюу Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь байгууллага, аж ахуйн нэгжийн дунд томоохонд орох татвар төлөгч аж ахуйн нэгж юм.

2011-2016 онд төлсөн татварын хэмжээг хүснэгтээс харвал:

Татварын төрөл	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
Үл хөдлөх хөрөнгийн орлогын албан татвар	22,774,600	35,975,925	47,593,936	47,953,936	28,556,365	17,940,365
Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар	433,400	282,118	464,740	574,900	482,275	299,940
Газрын төлбөр	320,000	480,000	400,000	400,000	400,000	400,000
Нэмэгдсэн өртгийн орлогын албан татвар	14,934,687	45,033,606	42,310,698	43,335,267	59,446,662	39,042,992
Хувь хүний орлогын албан татвар	9,678,791	13,892,548	16,472,167	20,397,566	22,411,896	12,989,953
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	12,362,365	11,066,987	23,065,456	27,623,094	122,285	0
Нийт дүн	60,503,843.00	106,731,184.00	130,306,997.00	140,284,763	111,419,483	70,673,250

Жич: Голлох татварын хэмжээг харуулав.

Үүнээс гадна нийгмийн даатгалын санд төлсөн даатгалын шимтгэлийг харвал:



1.6 Нийгмийн хариуцлагын тайлан

Байгууллагынхаа гадна, дотно тохижилтын ажлыг хамт олны хүчээр хийж “Ногоон байгууламж бидний орчин” гэсэн аяныг ажилчдын дунд өрнүүлэн Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 04-р сарын 14-ны өдөр батлагдсан “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” шийдвэрийн дагуу компанийн байрны урд талаар 2 төрлийн мод, сөөгийг нэмж тарьсан.

Замын-Үүд суманд үйл ажиллагаагаа явуулахад ажиллах хүчний тогтвор суурьшил муу, шилжилт хөдөлгөөн их байдагтай холбоотойгоо ажлын тасралтгүй үйл ажиллагаа явуулах нөхцөл байдал доголдолтой байдаг нь ажилд сөргөөр нөлөөлдөг. Иймээс бид орон нутгийн харъяат иргэдээс залуу боловсон хүчнийг сургах, чадавхжуулах, мэргэжил дээшлүүлэн компанидаа ажилуулах тал дээр ихээхэн анхаарч ажиллаж байна. Одоогийн байдлаар тус компанийн ажилчдийн 23 нь буюу нийт ажилчдын 74,1%-ийг Замын-Үүд суманд оршин суудаг, сумын харъяат иргэд эзэлж байгаа бөгөөд үлдсэн 8 буюу 25,8%-ийг түр оршин суугч иргэд эзэлж байна.

Ажилчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх үүднээс ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх тал дээр түлхүү анхаарч ажиллаж шаардлагатай зээл тусламж авахад дэмжлэг үзүүлэх, нийтээр тэмдэглэн өнгөрүүлэх баярыг хамт олон, гэр бүлээрээ тэмдэглэх, спортын болон хөгжөөнт тоглоом, тэмцээн уралдаан зохион байгуулах зэрэг олон төрлийн арга хэмжээг зохион байгуулж ажилласан.

2.УДИРДЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2.1. Компанийн удирдлагын бүтэц бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт;
Компанийн удирдлагын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй болно.

2.2. Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл;

Гүйцэтгэх удирдлага

д/д	Овог нэр	Албан тушаал	Боловсрол, мэргэжил	Ажлын туршлага
1.	Чулуун Амарсанаа	Гүйцэтгэх захирал	Дээд, уулын инженер	Тус компанийг үүсгэн байгуулсан.
2.	Эрдэнэбаатар Ариунтуяа	Ерөнхий нягтлан бодогч	Дээд, математикч, нягтлан бодогч	2011 оноос хойш ажиллаж байна.
3.	Хаваан Батхишиг	Менежер	Дээд, бизнесийн удирдлага	2012 оноос хойш ажиллаж байна.
4.	Гомбо Оюунгэрэл	Гаалийн хяналтын талбайн эрхлэгч	Дээд, багш	2011 оноос хойш ажиллаж байна.
5.	Ванданлхүндэв Баасансүрэн	Ачаа тээврийн ахлах мэргэжилтэн	Дээд, Эрүүл ахуйч	2011 оноос хойш ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл

Компанийн 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгосон.

д/д	Овог нэр	Албан тушаал	Боловсрол	Ажлын туршлага
1.	Чулууны Энхболд	ТУЗ-ын дарга	Дээд	Э-Транс ХХК, Ерөнхий захирал
2.	Чулууны Амарсанаа	ТУЗ-ын гишүүн	Дээд	Э-Транс Ложистикс ХК, Гүйцэтгэх захирал
3.	Санжмятавын Отгонбаяр	ТУЗ-ын гишүүн	Дээд	Э-Транс ХХК, Ерөнхий менежер
4.	Сэджавын Санжаа	ТУЗ-ын гишүүн	Дээд	Мэдээлэл аудит ХХК, мэргэжилтэн
5.	Баярсайханы Пүрэвбаатар	ТУЗ-ын гишүүн	Дээд	Говь Караван ХХК, Санхүүгийн шинжээч
6.	Хүрэлбаатарын Болд	ТУЗ-ын гишүүн	Дээд	Би Ди Сек ХК, Мэргэжилтэн
7.	Бүрэнмэндийн Лхагвадорж	ТУЗ-ын гишүүн	Дээд	Би Ди Сек ХК, Тэргүүн дэд захирал
8.	Ариунболдын Батболд	ТУЗ-ын гишүүн	Дээд	Оптималь проект ХХК, Захирал
9.	Халтарын Батхишиг	ТУЗ-ын гишүүн	Дээд	Нефть Ойл ХХК, Гүйцэтгэх захирал

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Б.Пүрэвбаатар 2017 оны 08 дугаар сарын 28-ны өдөр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ хүргүүлсэн.

2.3. Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ, тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны талаарх мэдээлэл

д/д	Овог нэр	Албан тушаал	Цалин урамшууллын хэмжээ	Эзэмшиж буй хувьцааны тоо
Төлөөлөн удирдах зөвлөл				
1.	Чулууны Энхболд	ТУЗ-ын дарга	0₮	Эзэмшдэггүй
2.	Чулууны Амарсанаа	ТУЗ-ын гишүүн	сарын 1.100.000	Эзэмшдэггүй
3.	Санжмятавын Отгонбаяр	ТУЗ-ын гишүүн	0₮	Эзэмшдэггүй
4.	Сэджавын Санжаа	ТУЗ-ын гишүүн	0₮	Эзэмшдэггүй
5.	Баярсайханы Пүрэвбаатар	ТУЗ-ын гишүүн	0₮	Эзэмшдэггүй
6.	Хүрэлбаатарын Болд	ТУЗ-ын гишүүн	0₮	Эзэмшдэггүй
7.	Бүрэнмэндийн Лхагвадорж	ТУЗ-ын гишүүн	0₮	Эзэмшдэггүй
8.	Ариунболдын Батболд	ТУЗ-ын гишүүн	0₮	Эзэмшдэггүй
9.	Халтарын Батхишиг	ТУЗ-ын гишүүн	0₮	Эзэмшдэггүй
Гүйцэтгэх удирдлага				
1.	Эрдэнэбаатарын Ариунтуяа	Ерөнхий нягтлан бодогч	Сарын 1.000.000₮	Эзэмшдэггүй
2.	Хавааны Батхишиг	Менежер	Сарын 1.000.000₮	Эзэмшдэггүй
3.	Гомбын Оюунгэрэл	Гаалийн хяналтын талбайн эрхлэгч	Сарын 1.000.000₮	Эзэмшдэггүй
4.	Нямсүрэнгийн Баярмаа	Касс-нярав	Сарын 700.000₮	Эзэмшдэггүй

2.4. ТУЗ болон түүний дэргэдэх хороод

д/д	Овог нэр	Эзэмшсэн мэргэжил, боловсрол	Хараат бус гишүүн эсэх	ТУЗ-ын хороодод томилогдсон байдал
1.	Чулууны Энхболд	Ленинградын Төмөр замын дээд сургууль, Төмөр замын инженер	Энгийн	
2.	Чулууны Амарсанаа	ЗХУ-ын Свердловск хотын Уулын дээд сургууль, Уулын инженер	Энгийн	Нэр дэвшүүлэх хорооны дарга
3.	Санжмятавын	Худалдаа үйлдвэрлэлийн	Энгийн	Цалин

	Отгонбаяр	дээд сургууль, Бизнесийн удирдлага		урамшууллын хорооны дарга
4.	Сэджавын Санжаа	Санхүү эдийн засгийн техникум	Хараат бус	Аудитын хорооны дарга, Цалин урамшууллын хорооны гишүүн
5.	Баярсайханы Пүрэвбаатар	University Tomas Bata in Zlin, Czech Republic, Business Administration	Энгийн	
6.	Хүрэлбаатарын Болд	Зохиомж дээд сургууль	Энгийн	Аудитын хорооны гишүүн
7.	Бүрэнмэндийн Лхагвадорж	ШУТИС, Нефтийн инженер	Энгийн	
8.	Ариунболдын Батболд	Санкт-Петербургийн төмөр замын дээд сургууль, төмөр замын инженер, бизнесийн удирдлагын магистр	Хараат бус	Нэр дэвшүүлэх хорооны гишүүн, цалин урамшууллын хорооны гишүүн
9.	Халтарын Батхишиг	ШУТИС, Нефтийн инженер	Хараат бус	Аудитын хорооны гишүүн, нэр дэвшүүлэх хорооны гишүүн

Компани нь 2017 оны 04 дүгээр сарын 28-нд “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ыг зарлан хуралдуулж, ТУЗ-ын гишүүдийг улируулан сонгосон бөгөөд 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдөр ТУЗ-ийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 17/04 тоот тогтоолоор баталгаажуулсан.

- Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороог С.Санжаа, Х.Батхишиг, Х.Болд гэсэн бүрэлдэхүүнтэй байгуулан Аудитын хорооны даргаар ТУЗ-ын хараат бус С.Санжаа гишүүнийг томилсон.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хороог С.Отгонбаяр, С.Санжаа, А.Батболд гэсэн бүрэлдэхүүнтэй байгуулан Цалин, урамшууллын хороог С.Отгонбаяр гишүүнийг томилсон.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хороог Ч.Амарсанаа, Х.Батхишиг, А.Батболд гэсэн бүрэлдэхүүнтэй байгуулан Нэр дэвшүүлэх хорооны даргаар Ч.Амарсанааг томилсон.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод тус бүр 2-3 удаа хуралдаж тодорхой асуудлуудыг шийдвэрлэсэн.

2.5. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан

Компанийн гүйцэтгэх удирдлага нь улс оронд үүсээд байгаа эдийн засгийн хүнд байдлын үед компанийн санхүүгийн нөхцөл байдал алдагдалтай ажилласан нь үйл ажиллагааг зогсоолгүй хэвийн хэмжээнд байлгах зорилгоор шаардлагатай бүхий л үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласан. Удирдлагаас 2018-2019 оны хооронд компанийн үйл ажиллагааг сайжруулах боломжит нөхцөл байдлыг тусгасан богино

хугацааны бизнес төлөвлөгөөг боловсруулан удирдлагын түвшинд хэлэлцэн төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахад бэлэн болголоо. Улс орны эдийн засгийн нөхцөл байдал зарим салбарт сайжирах байдал ажиглагдаж байгаа нь цаашид компанийн үйл ажиллагаа үүнийг даган нэмэгдэх боломжтой юм.

Гүйцэтгэх удирдлагаас компанийн үндсэн үйл ажиллагаа болох шилжүүлэн ачих үйл ажиллагаанаас гадна өөр ажил үйлчилгээг компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх чиглэл барин ажиллаж байгаа бөгөөд компанийн үйл ажиллагааны богино хугацааны бизнес төлөвлөгөө болон 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдэд тусган одоогоор судалгаа шинжилгээний ажлыг хийж байна.

2.6. “Компанийн засаглалийн кодекс”-ын хэрэгжилтийн талаарх үнэлгээний тайлан

Тус компани нь “ Компанийн засаглалийн кодекс “-ийг мөрдөн дагаж ажиллаж байгаа бөгөөд өөрийн компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллээ компанийн өөрийн веб сайт, Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн бирж, Монголын Компанийн засаглалийн үндэсний зөвлөлийн веб сайтуудад тавьж олон нийт болон хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангаж байгаа болно.

3. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

3.1. Компанийн хагас жилийн санхүүгийн тайлан, санхүүгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ;

НББ-ийн дансны нэгдсэн зааврын дагуу үндсэн дансуудыг ангилан, туслах дансуудыг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан коджуулан хэрэглэж байгаа бөгөөд дансны жагсаалт нь баланс болон орлого, үр дүнгийн тайлангуудын дансуудаас бүрддэг. Санхүүгийн жилийн татвар ногдох орлого, зардлаа Монгол Улсын Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хууль болон бусад холбогдох хуулийн хүрээнд бэлтгэн тайлагнадаг.

Санхүүгийн тайлангаа НББ-ийн аккруэл суурьд үндэслэн бэлтгэдэг ба холбогдох хуулийн дагуу улирлын тайлангаа дараа сарын 20-ны дотор, жилийн тайлангаа дараа оны 2 сарын 10-ны дотор баталгаажуулан Төрийн сан болон Татварын хэлтэс, МХБ, СЗХ зэрэг байгууллагуудад хүргүүлдэг. Мөн бид санхүүгийн тайлангаа өөрийн веб сайтандаа байршуулдаг ба энэ нь манай дотоодын харилцагч нараас гадна дэлхийн аль ч улс орноос харилцагчид санхүүгийн мэдээллийг бодитой, шуурхай авах боломжийг олгодог.

Санхүүгийн байдал

Үзүүлэлт	2017 оны 01-р сарын 01	2017 оны 12-р сарын 30
Эргэлтийн хөрөнгийн дүн	98,006,809.47	100,005,544.02
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,754,777,573.17	5,497,463,785.06
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,852,784,382.64	5,597,469,329.08
Өр төлбөрийн нийт дүн	278,398,320.28	405,964,945.97
Эзэмшигчдийн өмчийн дүн	5,574,386,062.36	5,191,504,383.11

Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	5,852,784,382.64	5,597,469,329.08
--	-------------------------	-------------------------

Орлого үр дүн

Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого (цэвэр)	345,066,887.27
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	
Нийт ашиг (алдагдал)	345,066,887.27
Түрээсийн орлого	37,500,000.00
Хүүний орлого	21,658.23
Бусад орлого	87,785,818.18
Ерөнхий ба удирдлагын зардал	822,042,386.48
Санхүүгийн зардал	26,909,650.28
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-7,082.88
Бусад ашиг (алдагдал)	-4,294,757.47
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-382,879,513.43
Орлогын татварын зардал	2,165.82
Татварын дараах ашиг (алдагдал)	382,881,679.25
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	382,881,679.25
Орлогын нийт дүн	

3.2. Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээлэл;

Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний гэрээ хэлцэл хийгдээгүй болно.

3.3. Жилийн туршид авсан зээлийн жагсаалт, түүний эргэн төлөлт болон барьцаа, баталгаа гаргасан талаарх мэдээлэл

Огноо	Зээлийн төлөлт	Үлдэгдэл
	Зээлийн эхний үлдэгдэл	149,459,000.00
17.12.31	67,405,000	82,054,000
	Зээлийн үлдэгдэл 2017 оны 12-р сарын 31	82,054,000

Худалдаа хөгжлийн банкнаас 3 жилийн хугацаатай сарын 1,8%-ийн 200,000,000 сая төгрөгний зээлийн үлдэгдэл нь 82,054,000 төгрөг байна.

4. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

4.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэр

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2017.04.28-ны өдөр нийт хувьцааны 93.02% буюу 42,957,178 ширхэг хувьцаа эзэмшиж буй 7 хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнтэй хуралдсан. Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

- Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн 100% нь зөвшөөрсөн, 0% нь түтгэлзсэн, 0% нь татгалзсан.
- Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайланг хувьцаа эзэмшигчдийн 100% нь зөвшөөрсөн, 0% нь түтгэлзсэн, 0% нь татгалзсан байна.
- Компанийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хувьцаа эзэмшигчдийн 100% нь зөвшөөрсөн, 0% нь түтгэлзсэн 0% нь татгалзсан байна.
- Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг хувьцаа эзэмшигчдийн 100% нь зөвшөөрсөн, 0% нь түтгэлзсэн, 0% нь татгалзсан байна.
- ТУЗ-ын 2017 оны цалин урамшууллын төсвийг батлах тухай асуудлаар хувьцаа эзэмшигчдийн 100% нь зөвшөөрсөн, 0% нь түтгэлзсэн 0% нь татгалзсан байна.
- Ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн 100% нь зөвшөөрсөн, 0% нь түтгэлзсэн, 0% нь татгалзсан байна.
- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат гишүүдээр Ч.Энхболд, Б.Пүрэвбаатар, Х.Болд, С.Отгонбаяр, Ч.Амарсанаа, Б.Лхагвадорж нар, хараат бус гишүүдээр С.Санжаа, А.Батболд, Х.Батхишиг нар сонгогдсон.

4.2. Компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл;

д/д	Овог нэр / хуулийн этгээдийн нэр /	Албан тушаал	Хувьцааны хувь
1.	Э-Транс ХХК	Ачаа тээврийн компани	50%
2.	Би Ди Сек ХК	Брокер дилер, андеррайтэрийн компани	31.43%
3.	Монголиан Транспортэйшн Холдинг ХХК	Хөрөнгө оруулалтын сан, Люксембургийн вант улс	11.08%

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болох Чулууны Энхболд, гишүүн Санжмятавын Отгонбаяр, Баярсайханы Пүрэвбаатар, Хүрэлбаатарын Болд, Бүрэнмэндийн Лхагвадорж болон гүйцэтгэх захирал Чулууны Амарсанаа нар нь компанийн хараат гишүүд болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болох Ариунболдын Батболд, Халтарын Батхишиг, Сэджавын Санжаа нар нь компанийн хараат бус гишүүд болно.

4.3. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийн мэдээлэл;

Компани нь Э-Транс ХХК, Монголиан Транспортэйшн Холдинг ХХК, БиДиСек ҮЦК ХК гэсэн 5%-иас дээш хувь эзэмшдэг хувьцаа эзэмшигчтэй бөгөөд 2017 онд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсэд өөрчлөлт ороогүй болно.

5. НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

5.1. Компанийн тухайн жилийн ногдол ашгийн тухай;

Компани нь 2017 оны үйл ажиллагаа алдагдалтай байсан тул Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 02 дугаар сарын 19-ны хурлаар ногдол ашиг олгохгүй байхаар шийдвэрлэсэн байна.